



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 249

Улаанбаатар хот

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн  
үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Дарханы дулааны цахилгаан станц” ХК-ийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 37,717,880 /гучин долоон сая долоон зуун арван долоон мянга найман зуун ная/ ширхэг энгийн хувьцааг хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдүүлсэнтэй холбогдуулан 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 63,298,401 /жаран гурван сая хоёр зуун ерэн найман мянга дөрвөн зуун нэг/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлж нийт 101,016,280 /нэг зуун нэг сая арван зургаан мянга хоёр зуун ная/ ширхэг хувьцаатай байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөн бүртгэхийг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/, Хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 505 дугаар тогтоолоор “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Дарханы дулааны цахилгаан станц” ХК /О.Нямдаваа/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000259